



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Нийслэлийн Соёл урлагийн газрын балансаас хөрөнгө шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нэгдүгээр хавсралтад заасан 1,188,000 /нэг сая нэг зуун наян найман мянган/ төгрөгийн хөрөнгийг Налайх дүүргийн Соёлын ордны балансад, 1,179,800 /нэг сая нэг зуун далан есөн мянга найман зуун/ төгрөгийн хөрөнгийг Багануур дүүргийн Соёлын ордны балансад, хоёрдугаар хавсралтад заасан 2,162,632 /хоёр сая нэг зуун жаран хоёр мянга зургаан зуун гучин хоёр/ төгрөгийн хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордны балансад тус тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Соёл урлагийн газар /Ж.Дамдинцэрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Налайх дүүргийн Соёлын ордон /С.Баасанхүү/-д, Багануур дүүргийн Соёлын ордон /Ш.Ганцэцэг/-д, Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордон /Р.Мөнхсүрэн/-д тус тус даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн Соёл урлагийн газар /Ж.Дамдинцэрэн/-т, Налайх дүүргийн Соёлын ордон /С.Баасанхүү/-д, Багануур дүүргийн Соёлын ордон /Ш.Ганцэцэг/-д, Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордон /Р.Мөнхсүрэн/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА




Ч.ОДНАСАН

D:\Tushaal 2019-1\Tushaal-1\Тушаал 2019.docx

ТТА = 2371

115050000101



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 Төмөөн 2019 оны 02 сарын 08 өдрийн
 А.Б.А. тушаалын нэгдүгээр хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Соёл урлагийн газраас Багануур, Налайх дүүргийн Соёлын ордонд

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ				Хөрөнгө хүлээн авах байгууллага
						Нэгж үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн элэгдэл	Үлдэх хөрөнгө	
1	Компьютер	Lenovo	2010	ш	1	1,188,000	1,188,000	1,188,000	-	Налайх дүүргийн Соёлын ордон
3	Компьютер	DELL	2016	ш	1	1,179,800	1,179,800	1,179,800	-	Багануур дүүргийн Соёлын ордон
Машин, тоног төхөөрөмжийн дүн						2,367,800	2,367,800	2,367,800	-	
Нийт						2,367,800	2,367,800	2,367,800	-	

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2019 оны 08 сарын 18 өдрийн
 АБС-1 тушаалын хоёрдугаар хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр : Нийслэлийн Соёл урлагийн газраас Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Соёлын ордонд

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ				Хөрөнгө хүлээн авах байгууллага
						Нэгж үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн элэгдэл	Үлдэх хөрөнгө	
1	Компьютер	Lenovo	2010	ш	1	1,188,000	1,188,000	1,188,000	-	Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордон
Машин, тоног төхөөрөмжийн дүн						1,188,000	1,188,000	1,188,000	-	
2	Бичгийн ширээ		2010	ш	2	263,000	526,000	526,000	0	Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордон
3	Саарал ширээ		1999	ш	1	448,632	448,632	448,632	0	Сонгинохайрхан дүүргийн Соёлын ордон
Тавилга, эд хогшлын дүн						974,632	974,632	974,632	-	
Нийт						2,162,632	2,162,632	2,162,632	-	